 Огноо: 2024
 Хуудас: 6 3

"ОНЧ ТЭНХЛЭГ" ХХК
 Барилгын зураг, төсөл
 46 хэм, СБД, 11 хороо "PRO ONE" оффис
 1307 нөмөр ЧМЭС: 99807155, 99174540



ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧ НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ ҮҮСГЭХИЙН ӨМНӨХ ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ

Хүсэлт ирүүлсэн байгууллага: Хот Тохижилтын Газар ОНӨААТҮГ

Албан хүсэлт ирүүлсэн он, сар, өдөр: 2024.05.01

Албан хүсэлтийн дугаар: 01/196

Ажлын нэр: “Төвлөрсөн хогийн цэгүүдийн хог бүртгэлийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх” нэгдсэн платформ хөгжүүлж, нэвтрүүлэх программ хангамжийн ажлын техникийн даалгавар

Улаанбаатар хот, 2024 он

ҮНДЭСЛЭЛ

Хот Тохижилтын Газар ОНӨААТҮГ-аас “Төвлөрсөн хогийн цэгүүдийн хог бүртгэлийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх” нэгдсэн платформ хөгжүүлж, нэвтрүүлэх программ хангамжийн ажлын техникийн даалгаварын төсөлд зөвлөмж, дүгнэлт авах хүсэлтийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 01/196 дугаар албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд ирүүлсэн.

Мэдээлэл хариуцагчаас нийтийн мэдээллийн систем үүсгэх талаар мэдээллийг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд ирүүлэх, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, зөвлөмж дүгнэлт гаргахтай холбогдсон харилцааг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/18 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам”-аар зохицуулж байна. Энэхүү журамд Мэдээлэл хариуцагч систем үүсгэх тухай мэдээллийг тухайн системийн санхүүжилтийг батлуулахаас өмнө Цахим хөгжил, харилцаа холбооны яамны burtgel@mddc.gov.mn хаягт цахим хэлбэрээр ирүүлж, сайдын тушаалаар байгуулагдсан байнгын ажиллагаатай ажлын хэсэг нь ажлын 15 өдөрт багтаан цахим хэлбэрээр хариу зөвлөмж, дүгнэлтийг хүргүүлэхээр заасан.

Тус ажлын хэсэг нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.нийтийн мэдээллийн систем хоорондын харилцан уялдаа, 29.1.2.нийтийн мэдээллийн системийн эдийн засгийн үр ашигтай байдал, 29.1.3.хэрэглэх технологийн нийцэл, хүний хэрэглээнд тохирсон байдал, 29.1.4.аюулгүй, найдвартай байдлын шийдэл, 29.1.5.бусад шаардлагатай асуудал зэргийг хангаж байгаа эсэхийг нягталж зөвлөмж, дүгнэлт гаргана. Харин Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-аас ирүүлсэн “Төвлөрсөн хогийн цэгүүдийн хог бүртгэлийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ хөгжүүлж, нэвтрүүлэх программ хангамжийн ажлын техникийн даалгавар” нь Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны “Журам батлах тухай” А/18 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Мэдээлэл хариуцагчаас ирүүлэх мэдээллийн маягт”-ын дагуу биш байх тул ирүүлсэн материалд үндэслэн зөвлөмж, дүгнэлтийг боловсрууллаа.

**“ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН “ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГҮҮДИЙН
ХОГ БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ, МЭДЭГДЭЛ ХҮРГЭХ НЭГДСЭН ПЛАТФОРМ”
ХӨГЖҮҮЛЖ, НЭВТРҮҮЛЭХ ПРОГРАММ ХАНГАМЖИЙН АЖЛЫН ДААЛГАВРЫН
ТӨСӨЛД ХҮРГҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**

Монгол Улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын “Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам”-д тус тус заасны дагуу “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын “Төвлөрсөн хогийн цэгүүдийн хог бүртгэлийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ” хөгжүүлж, нэвтрүүлэх программ хангамжийн ажилд ЗӨВЛӨМЖ болгох нь:

1. Нийтийн мэдээллийн систем хоорондын харилцан уялдаа:

Ажлын даалгаварт “Хот Тохижилтын Газар” ОНӨААТҮГ нь төвлөрсөн хогийн цэгүүд дээр иргэд, аж ахуйн нэгж, гэрээт байгууллагуудаас ирж буй хогны тонн, жин болон хог тээвэр хийж буй автомашинуудтай холбоотой шаардлагатай мэдээлэл, мэдэгдлийг нэгдсэн байдлаар бүртгэх, хяналтын байгууллагад хүргэх платформуыг нэвтрүүлэх, бодит датаг цуглуулж дүн шинжилгээ хийх, ашиглах, төлбөр тооцоо хийх, захиалагчтай тогтмол харилцах, системийг одоо ашиглаж байгаа системүүдтэй холболт хийх зорилготойгоор системийн судалгаа, хэрэглэгчийн шаардлага тодорхойлох, үйл ажиллагааны зураглал, төслийн дизайн боловсруулах, техникийн дизайн, ерөнхий архитектур, дэд системүүдийн бүтэц, өгөгдлийн сангийн загвар, системийг боловсруулах, захилагчтай тогтмол харилцах, системийг одоо ашиглаж байгаа системүүдтэй холбогдох API хөгжүүлэлт, цаашид өөр байгууллагын цахим системтэй холбогдох API хөгжүүлэлт зэрэг зорилтуудыг төлөвлөсөн ба дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байна.

Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор баталсан “Төрөлжсөн бүртгэлийн жагсаалт”-д “Хог хаягдлын мэдээллийн сан” гэж бүртгэгдсэн байна. Энэ нь мэдээлэл хариуцагч хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төрөлжсөн мэдээллийн санг үүсгэнэ гэсэн хуульд заасан шаардлагыг хангаж байна. Шинээр хийгдэх системийн өргөтгөл, хөгжүүлэлт, сайжруулалтын дүнд хийгдэх үйлчилгээ нь үндсэн болон дэмжих системээр дамжуулан авах буюу давхардуулж үүсгэхгүй байх бодлого, чиглэлийг баримтлахад онцгой анхаарах шаардлагатай. Үүнд:

- Шинээр систем үүсгэхэд үйлчилгээ нь үндсэн болон дэмжих системээр дамжуулан авах буюу давхардуулж үүсгэхгүй байх бодлого, чиглэлийг баримтлах;
- Мэдээлэл хариуцагч хооронд харилцан мэдээлэл солилцоход төрийн болон албаны нууцын тухай хууль, хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, бусад

- холбогдох мэдээлэл солилцооны журамд нийцүүлэн салбар хоорондын холбоо, хамаарлыг тодорхойлж ажлын даалгаварт тусгах;
- Мэдээлэл хариуцагчийн систем ашиглах болон байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журамд нийцсэн кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журамтай байх;
 - Мэдээлэл хариуцагчийн системийн хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг хангах зорилго бүхий танилт, нэвтрэлтийн систем, нийтийн түлхүүрийн дэд бүтэц, мэдээлэл солилцооны бүртгэлийн систем, мэдэгдэл хүргэх систем, албан бичиг солилцооны дундын систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, төлбөр тооцооны систем зэрэг бие даасан мэдээллийн системүүдтэй харилцан уялдаатай байх, тэдгээрийн техникийн нөхцөл, шаардлагад нийцүүлэх; /Дэмжих системд холбогдох техникийн нөхцөл, шаардлагыг хавсралтаар оруулав/;
 - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан эдийн засаг, бизнесийг дэмжих, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх нээлттэй өгөгдлийг opendata.gov.mn порталд байршуулах;
 - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг бусад системтэй солилцох боломжтой байх;
 - Төрийн болон хувийн аж ахуйн нэгжүүдийн системүүдтэй холбогдож ажилладаг байхаар шийдлийг боловсруулах. Үүнд:
 - Байгаль орчин, аялал жуулчлалын яам;
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам;
 - Эрүүл мэндийн яам;
 - Барилга, хот байгуулалтын яам;
 - Үндэсний Статистикийн хороо;
 - Онцгой байдлын ерөнхий газар;
 - Гаалийн ерөнхий газар (CAIS болон бусад систем);
 - “Оюу Толгой” ХХК-ийн хог хаягдлын удирдлагын төв;
 - “Пластик центр” ХХК;
 - “ТЧМ” ХХК;
 - “Сан-Оргиу” ХХК;
 - “Алтан оршихуй” ХХК
 - “Ахуйн мандал” үйлдвэр;
 - Элемент ХХК болон бусад. Тус хуулийн этгээдүүд нь нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 заалтад хамаарагдаж байгаа тул нийтийн мэдээлэл хариуцагч гэж үзнэ.
- Мэргэжлийн холбооны хуулийн 4 дүгээр зүйлийн хэрэгжилтийг тусгасан байна.

Дээрх байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох нь хогны тонн жин, болон тээвэрлэлт, хяналтын үйл ажиллагаа, мэдээллийн сан үүсгэх, нийтийн мэдээллийн дэд бүтэц харилцан уялдаатай, нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх, мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой, үнэн зөв, бүрэн, шуурхай, хялбар байх, зарчимтай нийцнэ. Ингэхдээ

мөн тус хуулийн 18.9-т “Мэдээлэл хариуцагч хоорондоо болон мэдээлэл хариуцагчаас хүн, хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр мэдээлэл солилцохдоо үндсэн системийг ашиглана.” гэж заасны дагуу үндсэн систем буюу “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системд API холболт хийж мэдээллээ солилцох боломжтой. /Төрийн мэдээлэл солилцооны системтэй холболт хийх зааврыг 1-р хавсралтаар оруулав/;

2. Нийтийн мэдээллийн системийн эдийн засгийн үр ашигтай байдал:

Суурь мэдээллийн сангийн мэдээлэл буюу улсын бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлд үндэслэн мэдээлэл хариуцагчаас хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд мэдээллийг харилцан солилцож, төрөлжсөн мэдээллийн санг үүсгэх нь мэдээллийн давхардал үүсэхгүй, үр ашиггүй зардлыг бууруулах, эдийн засгийн хэмнэлтийг бий болгох, ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хог хаягдлын дахин боловсруулах хэмжээг 2030 он гэхэд 40 хувьд хүргэж, “Ногоон хөгжлийн бодлого”-д байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг 40 хувиар бууруулах зорилт дэвшүүлжээ. Монгол улсад жилд дунджаар 3.4 сая тонн хог хаягдал гардаг бөгөөд сүүлийн таван жилд 18.3 хувиар өсч, 2040 он гэхэд одоогийнхоос 21 хувиар өсөх хандлагатай байна. Иймд “Хог хаягдлын тухай хууль”-ийн 6 дугаар бүлгийн 40 дүгээр зүйлийн 40.4-д “Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, байгууллага, аж ахуй нэгжид эдийн засгийн урамшуулал олгоно”, 41¹.2-д “Хог хаягдлын салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд зааснаар зохицуулна гэсэн заалтуудын хэрэгжилтийг системд тусгасан байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.4.2-т “Үүсэх хог хаягдлыг бууруулах, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн эко төлбөрийн эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хэрэгжүүлнэ.”, 6.4.4-т “Бохирдол, хаягдлыг бууруулах, нөөцийн хэмнэлттэй байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, цэвэр үйлдвэрлэл, хэмнэлттэй хэрэглээг эдийн засгийн хөшүүргээр дэмжинэ.”, 9.2.27-д “Бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг нэмэгдүүлэхэд захиргааны болон урамшууллын аргыг хослуулан хэрэглэнэ.”, 9.2.29-д “Хог хаягдлыг ангилан ачих, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж, стандартыг бий болгох, дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлэх, хог хаягдлын төвлөрсөн” гэсэн заалтын хэрэгжилтийг системд тусгах гэсэн үйл ажиллагааг тус тус тусгасан байна.

Мөн Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооноос хог хаягдал, орчны бохирдлыг шийдвэрлэхэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог бодитойгоор нэмэгдүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд

оруулах эко төлбөрийн эрх зүйн зохицуулалт бий болгох, хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд заасан өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулан санал (Түгжрэлийг бууруулах үндэсний хорооноос ирүүлсэн 2024.04.11, 01/230 дугаар албан бичиг хавсаргав) авсан байна.

Зөвлөмж, дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн баримтаас үзвэл платформ нь цахим бүртгэл хөтлөх, мэдэгдэл хүргэх, хогны жин, автомашин, ТҮК болон гэрээт аж ахуйн нэгж, иргэний мэдээллийг бүртгэх, дамжуулахад чиглэсэн байна. Энэ нь дээрх бодлого, үйл ажиллагаатай уялдуулан, хог хаягдалтай холбоотой асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатайг харуулж байна.

3. Хэрэглэх технологийн нийцэл, хүний хэрэглээнд тохирсон байдал:

Мэдээлэл хариуцагчийн системийн хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг хангах зорилго бүхий танилт, нэвтрэлтийн систем, нийтийн түлхүүрийн дэд бүтэц, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, төлбөр тооцооны систем зэрэг бие даасан мэдээллийн системүүдтэй харилцан уялдаатай байх, техникийн нөхцөл, шаардлагад нийцүүлэх;

Суурь болон төрөлжсөн мэдээллийн сан, түүний нөөцийг Үндэсний дата төвд хадгална. Мэдээлэл хариуцагчийн системийг Үндэсний дата төвд байршуулж болно.

4. Аюулгүй, найдвартай байдлын шийдэл:

Ерөнхий мэдээллийн 5 дугаарт заасан Төслийг хүрээнд хийгдэх ажилд дараах заалтыг тусгах:

- Үндсэн систем, дэд системийн архитектурыг боловсруулахад аюулгүй байдлын зохих шаардлагуудыг хангах.

Ерөнхий мэдээллийн 6 дугаарт заасан Мэдэгдлүүдэд дараах заалтыг нэмж тусгах:

- Аюулгүй байдлын халдлага, зөрчил илэрсэн талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээллийн 10.2 дугаарт "ISO/IEC 27001" гэснийг "ISO/IEC 27001:2022" гэж өөрчлөх.

1. Хөгжүүлэлтийн үе шат дахь аюулгүй байдал:

- Сайн туршлага: Хөгжүүлэлтийн үед Secure coding practices буюу сайн туршлагыг ашиглах SQL Injection болон Buffer overflow зэрэг түгээмэл байдаг эмзэг байдлыг гарахаас сэргийлэх.
- Оролтыг хянах: Хэрэглэгчээс оруулах утгуудыг нягтлан шалгаж, Injection төрлийн халдлагаас сэргийлэх.
- Анализ хийх: Кодод анализ хийх программ хангамж, хэрэгсэл ашиглан код дахь эмзэг байдлыг эрт илрүүлэх.

- Нэвтрэлтийн туршилт – Систем, аппликейшнийг ашиглаж эхлэхээс өмнө кибер аюулгүй байдлын мэргэжилтэн, тус чиглэлийн хуулийн этгээдээр нэвтрэлтийн туршилтыг хийлгэж, эмзэг байдлуудыг тодорхойлох.

2. Өгөгдлийн хамгаалалт:

- Өгөгдөл хадгалах: Хэрэглэгчийн эмзэг мэдээллийг шифрлэж хадгалах.
- Өгөгдөл дамжуулах: Хэрэглэгчийн эмзэг мэдээллийг дамжуулахдаа /server-client app/ шифрлэлт ашиглах.
- Өгөгдлийг багасгах: Аппликейшний цуглуулж, хадгалах өгөгдлийг хамгийн бага байлгах.
- Хандалт удирдлага: Эмзэг мэдээлэлд хандах хандалтыг хязгаарлаж, хандалтад хяналтыг хийх.

3. Бусад

- Шинэчлэл: Шинээр гарч буй халдлага, эмзэг байдлаас сэргийлж систем, аппликейшнд шинэчлэлтийг тогтмол хийх.
- Эмзэг байдал: Систем, аппликейшнд илэрсэн эмзэг байдлыг мэдээлэх хамгаалалт бүхий сувагтай байх.
- Мэдээлэх: Аппликейшний шинэчлэлтийг дэмжих зорилгоор илэрч хамгаалалт хийгдсэн эмзэг байдлыг мэдээлэх ажилбар, сувагтай байх.

5. Бусад шаардлагатай асуудал:

- Ажлын даалгаварт дараах шаардлагыг тусгах:
 1. функциональ бус шаардлагыг илүү тодорхой болгох;
 2. системийн цаашдын тогтвортой байдлыг хангах, ашиглалт, үйлчилгээний төлөвлөгөөг тодорхойлох;
 3. системийн хэрэглэгчийн гарын авлага, сервис үйлчилгээний гарын авлага, администраторын тохиргооны гарын авлага зэргийг боловсруулах талаар тусгах;
 4. “Төрийн байгууллагын үүлэн тооцооллын системийн үйлчилгээ”-д нийцүүлэх;
 5. гүйцэтгэгчид тавигдах шаардлагыг тодорхойлох.
- “Төвлөрсөн хогийн цэгүүдийн хог бүртгэлийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ” хөгжүүлэх ажлын хүрээнд “Хог хаягдлын мэдээллийн сан” -тай холбоотой дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Үүнд:
 1. Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 77 дугаар тогтоолоор баталсан “Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим

- хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам"-д заасан нөхцөл, шаардлагыг ажлын даалгаварт тусгаж, хэрэгжүүлэх;
2. Төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах тухай бүр бүртгүүлэх арга хэмжээ авах;
 3. "Төвлөрсөн хогийн цэгүүдийн хог бүртгэлийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ"-ын ашиглалтын нөхцөл байдлыг харгалзан "Төрийн үүлэн систем"-д нийцсэн байх (SaaS) түвшний шаардлага хангасан байхаар ажлын даалгаварт тусгах;
- Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;
 - Системийн зорилгоос харахад хог тээвэр хийж байгаа автомашинуудтай холбоотой мэдээлэл, мэдэгдлийг нэгдсэн байдлаар бүртгэн, дүн шинжилгээ хийхээр байна иймд техникийн даалгаварт хогийн машины хяналтын систем болон хяналтад шаардлагатай gps төхөөрөмж, хогийн савны мэдрэгч төхөөрөмжүүдийн талаар тусгах;
 - Тендерийг зохион байгуулахдаа урьдчилан зөвлөх үйлчилгээ авах, зөвлөх үйлчилгээнээс гарсан тайлангийн дагуу систем хөгжүүлэх ажлын даалгаврыг нарийвчлах.

ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН “ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГҮҮДИЙН
ХОГ БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ, МЭДЭГДЭЛ ХҮРГЭХ НЭГДСЭН ПЛАТФОРМ”
ХӨГЖҮҮЛЖ, НЭВТРҮҮЛЭХ ПРОГРАММ ХАНГАМЖИЙН АЖЛЫН ДААЛГАВАРЫН
ТӨСЛИЙН ДҮГНЭЛТ

Хот Тохижилтын Газар ОНӨААТҮГ-аас “Төвлөрсөн хогийн цэгүүдийн хог бүртгэлийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх” нэгдсэн платформ хөгжүүлж, нэвтрүүлэх программ хангамжийн ажлын техникийн даалгаварын төсөлд зөвлөмж, дүгнэлт авах хүсэлтийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 01/196 дугаар албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд ирүүлсэн.

“Төвлөрсөн хогийн цэгүүдийн хог бүртгэлийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ” хөгжүүлэхдээ өмнө үүсэж бий болсон мэдээллийн санд бүтцийн өөрчлөлт оруулах замаар шинэчлэх, мэдээллийн санг давхардуулан үүсгэхгүй байх хуульд заасан шаардлагыг хангаж ажиллах шаардлагатай.

Хог бүртгэлийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх хяналтын систем хөгжүүлэх нь хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд эерэг нөлөөтэй гэж дүгнэж байна.

Зөвлөмж, дүгнэлтэд дурдсан санал, зөвлөмжийг ажлын даалгаварт тусган нарийвчлан боловсруулахыг анхаарна уу.

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ СИСТЕМД ХОЛБОГДОХ ЗААВАР

Мэдээлэл авах, солилцох хүсэлтэй аливаа байгууллага нь Цахим Хөгжил Харилцаа Холбооны Яамтай гэрээ байгуулсны үндсэн дээр сүлжээ, системийн тодорхой шаардлага хангасны дагуу ХУР төрийн мэдээлэл солилцооны системд холбогдох боломж бүрдэх юм.

Д/д	Хэрэгжүүлэх алхам	Тайлбар
1.	Хүсэлт гаргах	Цахим хөгжил, харилцаа холбооны яамд албан хүсэлт гаргах
2.	Гэрээ байгуулах	Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай гэрээ байгуулах
3.	Холболт хийх	Төрийн мэдээлэл солилцооны системээр холбогдоно
4.	Туршилт	Сервис нэвтрүүлэх туршилт хийх

ХУР системийн VPN сүлжээнд холбогдох дараалал:

Д/д	Хэрэгжүүлэх алхам	Тайлбар
1.	Мэдээлэл солилцох:	Холбогдох хүсэлтэй байгууллага нь өөрийн төлөөлөн харилцах ажилтны мэдээлэл, цахим шуудангийн хаягийг албан бичгээр/гэрээгээр “Үндэсний дата төв”-д илгээн баталгаажуулна.
2.	Нийтийн түлхүүр солилцох:	Баталгаажсан цахим шуудан дээр “PGP” хос түлхүүр үүсгэн нийтийн түлхүүрээ солилцоно. Солилцохдоо https://pgp.datacenter.gov.mn/ цахим хуудсыг ашиглана. Цахим шуудангаар харилцах бүрд “PGP” түлхүүрээр зайлшгүй баталгаажуулсан байна.
3.	Хүсэлт илгээх:	“VPN” сүлжээнд холбогдох хүсэлтээ “Үндэсний дата төв”-ийн security@datacenter.gov.mn цахим шуудангийн хаягаар илгээнэ. Тус хүсэлтэд дараах мэдээллийг багтаасан байна. - Хандах хаягийн мэдээлэл /гадаад IP хаяг/ - Сертификат дээр бичигдэх мэдээлэл ○ Байгууллагын албан ёсны нэр ○ Хэлтэс, нэгжийн нэр ○ Цахим шуудангийн хаяг
4.	Эрх үүсгэх:	“Үндэсний дата төв”-өөс мэдээллийн дагуу хандалтын эрх, гэрчилгээ, хэрэглэгчийн нэр, нууц үгийг үүсгэн илгээнэ.

VPN сүлжээний нууцлал хамгаалалт:

Д/д	Тохиргоо	Тайлбар
1.	VPN:	OpenVPN
2.	Хэрэглэгчийг таних:	Гэрчилгээ, хэрэглэгчийн нэр, нууц үг
3.	Түлхүүрийн хэмжээ:	2048 bit RSA
4.	Удирдлагын суваг:	TLSv1.2
5.	Шифрлэлт:	TLSv1/SSLv3 ECDHE-RSA-AES256-GCM-SHA384
6.	Холбогдох порт:	1194/udp
7.	Гарах өгөгдлийн суваг:	Cipher 'AES-256-GCM' 256 bit key
8.	Орох өгөгдлийн суваг:	Cipher 'AES-256-GCM' 256 bit key

1. Системд холбогдох: /windows/

Дараах холбоосоор орж “OpenVPN” хэрэглэгчийн программыг татаж суулгана. <https://openvpn.net/community-downloads/>. Татаж авсан файлыг ажиллуулснаар дараах суулгац гарч ирнэ.



“Install Now” товчийг дарж суулгана.



1.2. Хэрэглэгчийн программыг амжилттай суулгасны дараа программыг ачаалахад систем дээр үйлдлийн систем суусан диск болох Жишээ нь: C:\Users\your user name\OpenVPN\config хавтас үүснэ. Тус хавтас дотор Үндэсний дата төвөөс өгсөн тохиргооны файлуудыг хуулна.


Жишээ нь:

Name	Date modified	Type	Size
Жишээ	2022.05.27 15:59	File folder	
password	2022.04.14 16:31	Text Document	1 KB
test	2022.04.14 16:34	OpenVPN Config ...	9 KB

OpenVPN GUI товч дээр хулганын хоёр дахь товчийг дарна.



Дараа нь өөрийн хуулсан нэр дээр хулганыг аваачиж "Connect" товчийг дарна.






Нэвтрэх нэр нууц үг асуух бөгөөд Үндэсний дата төвөөс өгсөн password.txt дотор байрлах нэвтрэх нэр, нууц үгийг оруулна.

```

*password - Notepad
File Edit Format View Help
test|
TVv1%gYT^t{ _n7x2$big73v)JFvmzqZ4

```

2. Гэрчилгээ нэмэх:

2.1. "Root CA certificate"-д гэрчилгээ нэмэх. /Дараах холбоосоор орж гэрчилгээг татаж авна/

- Үндэсний суурь гэрчилгээ: <https://esign.gov.mn/MNRCA.cer>
- Үндэсний олгох гэрчилгээ: <https://esign.gov.mn/MNICA-2021.cer>

2.2. Системийн "Trusted root certificate"-д татаж авсан гэрчилгээнүүдийг суулгах. Command prompt нээж гэрчилгээ татаж авсан хавтас руу шилжсэний дараагаар дараах командыг бичнэ:

```
certutil -addstore -f "ROOT" MNRCA.cer  
certutil -addstore -f "ROOT" MNICA.cer
```

2.3. Java хөгжүүлэлтийн орчинд "Trust Store"-т Root Certificate нэмэх. Command prompt нээж гэрчилгээ татаж авсан хавтас руу шилжсэний дараагаар дээр дараах командыг бичнэ.

```
#JRE_HOME таны систем дэх JAVA суулгасан JRE_HOME хавтас Жишээ нь:  
/usr/java/<Java version jre> эсвэл C:/Java/<Java version jre> гэх мэт.  
JRE_HOME/bin/keytool -import -trustcacerts -alias certAlias -file MNICA.cer -key store  
trustStoreFile  
#Гарч ирэх баталгаажуулах асуултад **YES** гэсэн утгыг оруулан ***Enter*** товчийг дарна.
```

2. Тохиргоо шалгах:

Start цэнээс notepad гэж хайлт хийн гарч ирэх програм дээр хулганы баруун товчийг дарж Run as Administrator дарж ажиллуулна. Програм нээгдсэний дараагаар Ctrl+O гарын хослолыг дарж гарах цонхон дээр C:\Windows\System32\drivers\etc\hosts утгыг оруулж Enter товч дарна. Файл нээгдсэний дараагаар дараах мөрийг шинэ мөр дээр нэмэн хадгална.

```
#Төрийн байгууллага бол  
x.x.x.x хур.gov.mn  
#Хувийн хэвшлийн байгууллага бол  
x.x.x.x хур.gov.mn
```

Үүний дараа интернет хөтөч нээн URI бичих хэсэгт <https://хур.gov.mn> гэж бичин хандаж үзэж хандалт secure байгаа хэсгийг шалгана

ДЭМЖИХ СИСТЕМД ХОЛБОГДОХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

№	Үндсэн болон дэмжих систем	Техникийн нөхцөл шаардлага
1	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем	<p>Үндсэн системд холболт хийгдсэн үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн системд нийлүүлнэ;</p> <p>Мэдээлэл солилцох формат нь "XML" болон "JSON" байх;</p> <p>Мэдээлэл солилцох протокол нь "HTTP", "SOAP", "REST" байх;</p> <p>Мэдээлэл солилцох систем хоорондын холболтыг "SSL" сертификатаар хамгаалсан байх;</p> <p>Үйлдлийн бүртгэлийг 5 жилийн хугацаанд хадгалах;</p> <p>Өөрийн системийн хандалт болон ачаалал даах чадварт үнэлгээ хийсэн байх;</p> <p>Бодит цагийн горим (real time)-д үйлчлэх үйлчилгээний хувьд үйлчилгээ үзүүлэх хугацааны "Response time" 3 секундээс хэтрэхгүй байх;</p>
2	Мэдэгдэл хүргэх систем	<p>Хэрэглэгч нь системийн веб интерфейс болон системийн API холболтыг ашиглана;</p> <p>Мэдээлэл, мэдэгдлийг "TEXT", "JSON", "XML" форматаар дамжуулна;</p> <p>"HTTP", "SOAP", "REST", "SS7", "SMTP", "WEB API" протоколуудыг ашиглана;</p> <p>Мэдээлэл, мэдэгдлийг "SMS", "EMAIL", "APP NOTIFICATION", "VOICE MESSAGE" гэсэн сувгуудаар хүргэх боломжтой бөгөөд хүргэх сувгаа тодорхойлно;</p> <p>Илгээх мэдээлэл, мэдэгдлийн боломжтой тоог И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газраар тодорхойлуулна;</p>
3	"DocX" албан бичиг солилцооны дундын систем	<p>"JSON" форматаар өгөгдөл дамжуулдаг байх;</p> <p>Тоон гарын үсгийн хэрэглээг бүрэн дэмжсэн байх;</p> <p>Тоон гарын үсгээр баталгаажсан файлуудыг хавсралтаар илгээдэг байх;</p> <p>Албан бичгийн шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг хүлээн авах, бусад системүүдэд дамжуулдаг байх;</p> <p>Техникийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа тохиолдолд файлын хэмжээнд хязгаарлалт тавихгүй байх;</p>

	Албан бичиг солилцох явцад саатал гарсан тохиолдолд нөхөж илгээдэг байх;
	"DocX" системийн мэдээлэл солилцоог харуулах хяналтын самбартай байх;
	Эрх бүхий байгууллага болон албан тушаалтанд зориулсан тайлан мэдээний модультай байх;


Танилцсан:

Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга



Б.Билэгдэмбэрэл

Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга




Д.Батбаяр

Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн шинжээч




Б.Отгонбаяр

Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн




Э.Балдансамбуу

“Үндэсний Дата Төв” УТҮГ-ын Мэдээллийн технологийн газрын дарга



Э.Баттөр

И-Монгол академи УТҮГ-ын Салбар хоорондын зохицуулалтын газрын дарга



Х.Энхманлай /Шахансар Зурал/

Боловсруулсан:

Цахим засаглалын хэлтсийн Мэргэжилтэн

Б.Гэрэлмаа

Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн мэргэжилтэн



Б.Лхагвадолгор

ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА..... Б.МӨНХЦЭЦЭГ
2024 оны ... сарын ... өдөр

БАТЛАВ.



**ТӨВЛӨРСӨН ХОГЫН ЦЭГҮҮДИЙН ХОГ БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ, МЭДЭГДЭЛ
ХҮРГЭХ НЭГДСЭН ПЛАТФОРМ ХӨГЖҮҮЛЖ, НЭВТРҮҮЛЭХ ПРОГРАММ
ХАНГАМЖИЙН АЖЛЫН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

Улаанбаатар хот

2024 он

АГУУЛГА

А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Захиалагч	1
2. Төслийн зорилго	1
3. Өнөөгийн байдал	1
4. Ашиглах хүрээ	1
5.Төсийн хүрээнд хийгдэх ажил	1
6. Системийн зорилт	2

Б. СИСТЕМД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

7. Системийн бүтэц, архитектурыг загварчлах	
8.Функциональ шаардлага	2
9. Функциональ бус шаардлага	3
10.Системийн тусгай шаардлага	4
11. Өгөгдлийн сангийн бүтэц	5
12. Найдвартай ажиллагаа	6

В. НЭВТРҮҮЛЭХ, ТУРШИЛТ БА БАТАЛГАА

13. Нэвтрүүлэх ажлууд	6
14. Нийтэд таниулах, сурталчлах	6
15. Сургалт, дадлага	6
16. Туршилт хийх	6
17. Баталгаат хугацаа	7
18. Гүйцэтгэх хугацаа	7

А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Захиалагч: Хот тохижилтын газар ОНӨААТҮГ

Нийслэлийг цэвэр, цэмцгэр хоггүй байлгах үндсэн чиг үүргийн хүрээнд тус газар нь Нарангийн энгэр, Цагаан даваа, Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгүүд дээр нийслэлийн хэмжээнд өдөрт дунджаар 3500-5000 тн ахуйн болон хатуу хог хаягдлыг хүлээн авдаг. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ- тай гэрээт байгууллагуудаас гадна, төвийн зургаан дүүргийн ТҮК-үүд, гэрээт бус аж ахуйн нэгж байгууллагууд, хувь иргэдээс ирсэн ахуйн болон хатуу хог хаягдлыг дээрх төвлөрсөн хогийн цэгүүд дээр хүлээн авч ландфил технологийн дагуу хөрсөөр дарж, булан устгаж хот суурин газрын төвлөрсөн хогийн цэгийн менежментийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж ажилладаг.

2. Төслийн зорилго

Мэдээлэл хариуцагч Хот Тохижилтын Газар ОНӨААТҮГ нь төвлөрсөн хогийн цэгүүд дээр иргэд, аж ахуйн нэгж, гэрээт байгууллагуудаас ирж буй хогны тонн жин болон хог тээвэр хийж буй авто машинуудтай холбоотой шаардлагатай мэдээлэл, мэдэгдлийг нэгдсэн байдлаар бүртгэх, хяналтын байгууллагад хүргэх платформыг нэвтрүүлэх, бодит дата-г цуглуулж дүн шинжилгээ хийх, ашиглах, төлбөр тооцоо хийх, захиалагчтай тогтмол харилцах, системийг одоо ашиглаж байгаа системүүдтэй холбож API хөгжүүлэх улмаар цаашдын санхүүгийн алдагдлаас урьдчилан сэргийлэх.

3. Өнөөгийн байдал

Тус газарт одоо ашиглагдаж байгаа хог бүртгэлийн системийг 2008 онд Жайкагийн төслөөр нэвтрүүлсэн. Тухайн программыг хөгжүүлэгч **"link engine" LLC** нь программынхаа лицензийг ашиглуулахаас татгалзсаны улмаас өнөөдрийг хүртэл хөгжүүлэлт хийгдээгүй тул байнга гацалт үүсч, гар аргаар бүртгэх улмаар санхүүгийн алдагдал хүлээх зэрэг эрсдэлүүд ихээхэн гарч байна. Программын эдгээр алдааг засварлуулахаар засвар үйлчилгээ хариуцдаг байгууллагуудад хандаж, программын хөгжүүлэлт хийх санал хүргүүлдэг хэдий ч анх программ хөгжүүлэлт хийсэн **"link engine" LLC**-ийн эх код (system source code) байхгүйн улмаас хамтран ажиллах байгууллага олддоггүй. Тус шалтгаанаас үүдэн одоо ашиглагдаж байгаа программыг цаашид хөгжүүлж ашиглахад хүндрэлтэй болсон тул төвлөрсөн хогийн цэгүүдийн хог хаягдлын тонн жин, хаяг бүртгэл, хяналтыг үнэн бодит хийхийн тулд шинэ дэвшилтэд программ хангамж хөгжүүлэх, ашиглах хэрэгцээ шаардлага бодитоор үүсээд байна.

4. Ашиглах хүрээ

- УБЗАА, Нийслэлийн Тамгын газар, Хот тохижилтын газар

5. Төслийн хүрээнд хийгдэх ажил

- Системийн судалгаа хийх
- Хэрэглэгчийн шаардлагыг тодорхойлох
- Үйл ажиллагааны зураглал гаргах

- Төслийн дизайн боловсруулах
- Техникийн дизайн боловсруулах
- Ерөнхий архитектур боловсруулах
- Дэд системүүдийн ерөнхий бүтцийг тодорхойлох
- Өгөгдлийн сангийн загвар боловсруулах
- Системийг боловсруулах үйл ажиллагааг удирдах
- Захиалагчтай тогтмол харилцах
- Системийг одоо ашиглаж байгаа системүүдтэй холбогдох API хөгжүүлэх
- Цаашид өөр байгууллагын цахим системтэй холбогдох API хөгжүүлэх
- Үндсэн систем, дэд системийн архитектурыг боловсруулахад төрийн болон албаны нууцын тухай хууль, хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, аюулгүй байдлын зохих шаардлагуудыг хангах

6. Системийн зорилт

Хог бүртгэлийн цахим бүртгэл, хяналтын системийн сайжруулснаар ашиглалтын бүлгүүдэд үнэн бодит мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ /цаашид “систем” гэх/ -нь өдөр тутмын төвлөрсөн хогийн цэгүүдэд ирж буй хогний тн жин авто машиний мэдээлэл, дүүргүүдийн ТҮК болон гэрээт аж ахуйн нэгж, иргэний мэдээллийг бүртгэх, тооцоолох дамжуулах үүргийг гүйцэтгэнэ. Төрийн болон хувийн аж ахуйн нэгжүүдийн системүүдтэй холбогдож ажилладаг байхаар шийдлийг боловсруулах (Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 заалтад хамаарах этгээдүүд)

Мэдэгдлүүд нь дараах төрөлтэй байна.

Үүнд:

- Төвлөрсөн хогийн цэгүүдэд хандсан гэрээт аж ахуйн нэгж, хувь иргэн, дүүргүүдийн ТҮК-ийн авто машин, тн жин, бусад мэдээлэл;
 - Сануулга
 - Үйлчилгээ авах шаардлага гарсан талаарх сануулга; Татвар, хураамж, төлбөрийн мэдээлэл;
 - Танилт, нэвтрэх системийн амжилттай, амжилтгүй оролдлогын талаар мэдээлэл;
 - Тайлан тооцооны мэдээлэл;
 - Аюулгүй байдлын халдлага, зөрчил илэрсэн талаарх мэдэгдэл
 - Бусад.
- Систем нь иргэн, хуулийн этгээдэд дараах сувгаар мэдээлэл, мэдэгдлийг хүргэнэ. Үүнд:
- Цахим үйлчилгээний платформ;
 - Аппликейшнууд (PUSH болон бусад);
 - Зөөврийн төхөөрөмж(SMS);
 - Цахим шуудан;
 - HTML бичвэр(холбоос);
 - Бусад.

Б. СИСТЕМД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

7. Мэдээлэл хариуцагчийн системийн хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг хангах зорилго бүхий танилт, нэвтрэлтийн систем, нийтийн түлхүүрийн дэд бүтэц, мэдээлэл солилцооны дундын систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, төлбөр тооцооны систем зэрэг бие даасан мэдээллийн системүүдтэй харилцан уялдаатай байх, тэдгээрийн техникийн нөхцөл, шаардлагад нийцүүлэх (Дэмжих системд холбогдох техникийн нөхцөл, шаардлага)

-Шинээр систем үүсгэхэд үйлчилгээ нь үндсэн болон дэмжих системээр дамжуулан авах буюу давхардуулж үүсгэхгүй байх

-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан эдийн засаг, бизнесийг дэмжих, мэдээллийг ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх нээлттэй өгөгдлийг opendata.gov.mn порталд байршуулахаар байх

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан байнга ил тод нээлттэй байлгах мэдээллийг бусад системтэй солилцох боломжтой байлгах

Системийн бүтэц, архитектурыг загварчлах

Системийн бүтэц, архитектурыг загварчлахад дараах диаграмм болон хамаарлын зураглалыг гаргах шаардлагатай. Үүнд :

- UML диаграмм гаргах;
- Бизнес процессын диаграмм гаргах;
- Use case диаграмм гаргах;
- Table relationship diagram /Table-уудын хоорондын холбоосны зураглал/;
- Систем нь төрийн байгууллагуудад ашиглаж буй цахим үйлчилгээний, хүний нөөц, дотоод удирдлага, хяналтын дэд систем болон албан хэрэг хөтлөлтийн систем, өргөдөл, гомдлын систем, төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем, танилт нэвтрэлтийн нэгдсэн ДАН систем, нийтийн түлхүүрийн дэд бүтэцтэй интеграци хийх бүтэц, архитектурыг загварчлах.

8. Функциональ шаардлага

- Системийг нээлттэй эхийн платформ дээр хөгжүүлнэ. Цаашид өргөтгөх, нэмж хөгжүүлэх, шинэчлэх боломжоор хангагдсан байна.
- Систем нь дараах 3 үндсэн модультай байна. Үүнд:
 - Мэдэгдэл хүлээн авах, хадгалах, илгээх;
 - Хэрэглэгчийн хэсэг;
 - Тайлан, хяналт (dashboard).
- Систем нь Unicode стандарт дэмждэг, кирилл үсгээр бичигдсэн бичвэрийг латинд хөрвүүлж илгээх боломжтой байна;
- Бусад систем, платформиос хамааралгүй бие даан ажилладаг байх;
- Систем нь алслагдмал газарт оршин суудаг иргэд, эмзэг бүлгүүдийг хамрах боломжийг бүрдүүлсэн байна;
- Систем нь танилт нэвтрэлтийн системээс мэдэгдэл илгээх иргэнээ таньдаг байна;
- Систем нь мэдээллийг EBarimt, E-Mongolia гэх мэт түгээмэл ашиглагдаж буй аппликейшнуудад “мэдэгдэл” хэлбэрээр илгээдэг байх. /Тухайлбал, гаргаж өгсөн API –ын дагуу/;

- Бүрдэл хэсэг нь нэг ижил дизайны шийдэлтэй, хэрэглэхэд энгийн ойлгомжтой интерфэйс, дизайнтай байна;
- Бүх модулийн хэсгээс дурын баганаар мэдээлэл шүүх харах, хайлт хийх, эрэмбэлэх боломжтой байна;
- Тайланг олон төрлийн /excel, csv, word, pdf, xml/ форматаар татаж авах, хэвлэх боломжтой байна;
- Системийн аналитик мэдээллийг хэрэглэгчдэд нээлттэй харуулахуйц хяналтын самбар /dashboard/ нь веб интерфэйстэй байна;
- Нэгдсэн удирдлагын хэсэгт, бүх шатны тохируулга хийх боломжтой байх;
- Илгээсэн мэдээлэл, мэдэгдлийн түүхчилсэн /лог/ мэдээллийг хадгалдаг байна; Үүнд: Иргэний регистрийн дугаар, илгээсэн байгууллага, хэрэглэгчийн дугаар илгээсэн мэдээллийн дугаар г.м;
- Мэдээлэл илгээгч байгууллагуудын цахим системтэй туршилт хийх боломж бүхий туршилтын орчин бүрдүүлэх;
- Систем нь олон тооны мэдээллийн алдагдалгүй, ачааллаас сэргийлж "queue" дараалалд оруулж илгээдэг байна;
- Мэдээлэл хүлээн авагчид SMS, EMAIL, APP Notification, Voice message гэх мэт сувгуудаар мэдээлэл хүргэх боломжтой байна;
- Мэдээлэл илгээгч байгууллагуудын цахим системүүдээр мэдээлэл илгээх API гаргаж, мэдээлэл илгээх боломжтой байна;
- Мэдээлэл солилцох, хүргэх протокол : HTTP, SOAP, REST, SS7, SMTP, Web API;
- Мэдээлэл дамжуулах формат : TXT, XML, JSON;
- Үндэсний дата төвийн суурь, болон дэмжих системүүдтэй холбогдон ажиллана.
- Мэдээлэл солилцох систем хоорондын холболтыг SSL сертификатаар хамгаалсан байна;
- Систем ажиллаж байх үед сүлжээ болон техник хангамжид гарсан алдаанаас болж мэдээлэл алдагдахгүй байх боломжийг бүрдүүлсэн байх;
- Систем нь алдаа боловсруулах хэрэгслээр сайтар хангагдсан байна. Алдааны мэдээлэл нь маш тодорхой ойлгомжтой байна. (алдааны мэдээлэл, алдааны код, хэвийн ажиллуулахад шаардлагатай авах арга хэмжээ).

9. Функциональ бус шаардлага

- Одоо байгаа дэд бүтцийн орчныг судалж системийн архитектурыг боловсруулан захиалагч талаар баталгаажуулна;
- Гуравдагч талын мэдээллийн систем, сан, технологи ашиглах бол ашиглагч талд оюуны өмчийн зөрчилгүй байх;
- Эх кодын өөрчлөлтийг удирдах хэрэгсэл ашиглах бөгөөд захиалагч талд хяналтын эрх олгоно;
- Бусад системүүд дээр хийгдэх мэдээлэл солилцох API, сервис хөгжүүлэх нөхцөл шаардлага, заавар бэлтгэж өгнө;

- Төслийн явцад мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж гарсан дүгнэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авна;
- Системийн тохиргоо хийх, суурилуулах, аюулгүй ажиллагааны гарын авлагыг бэлтгэх;
- Системийн хөгжүүлэлтэд сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглана;
- Систем, өгөгдлийн сан нь Үндэсний дата төвийн үүлэн тооцооллын дэд бүтэц дээр байршуулж, системийг бүрэн хүлээлгэн өгнө;
- Захиалагч талд системийн эх кодыг бүрэн хүлээлгэж өгнө;
- Өгөгдлийн сан болон бусад мэдээлэл утсан, бүрэн бүтэн байдал нь алдагдсан үед нөөцөлсөн өгөгдлийг сэргээх аргачлал, төлөвлөгөө захиалагч талд гаргаж өгнө.
- Системийн цаашдын тогтвортой байдлыг хангах, ашиглалт, үйлчилгээний төлөвлөгөөг гаргах
- Төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах тухай бүр бүртгүүлэх арга хэмжээ авах

10. Системийн тусгай шаардлага

- ### 10.1 Мэдэгдэл хүлээн авах, хадгалах, илгээх модульд тавигдах шаардлага
- Мэдээлэл илгээгч байгууллагуудын эрх бүхий мэргэжилтнүүд тухайн системд нэвтрэх
 - Хүргэх мэдэгдлийг доорх сонголтоор оруулдаг байна.
 - Нийт хэрэглэгчдэд;
 - Бүлгээр;
 - Тухайлсан хэрэглэгчид.
 - Хүргэх мэдээллийг текст хэлбэрээр оруулах боломжтой байна
 - Мэдээлэл хүлээн авагчдыг жагсаалт хэлбэрээр файлаас оруулах боломжтой байна;
 - Илгээх мэдээллээ SMS, email, API аль хэлбэрээр явуулахаа сонгодог байна.
 - Ерөнхий мэдээллийг засаг захиргааны нэгжийн хуваарилалтын дагуу илгээх боломжтой байна;
 - Тухайн илгээсэн мэдээллийн дэлгэрэнгүй статистик тайлан авах боломжтой байна. /Хэдэн иргэнд илгээсэн, хүлээн авсан, амжилтгүй г.м/;
 - Мэдээлэл илгээгдэж дууссан, зогссон тохиолдолд байгууллагын хэрэглэгчид эргэн мэдээлдэг байна;
 - Мэдээлэл илгээгч байгууллагуудын системд холбогдох API гарган өгч мэдээлэл илгээх боломжтой байна;
 - Өөрийн байгууллагын илгээсэн нийт мэдээллийн статистик тоон мэдээллийг сонгосон хугацааны дагуу авах боломжтой байна.
 - Төрийн байгууллагын үүлэн тооцооллын системийн үйлчилгээнд нийцүүлэх (Saas)

10.2 Аюулгүй байдал

- Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа мэдээллийн аюулгүй байдлын стандарт, журмуудыг болон ISO/IEC 27001:2022 стандартын шаардлагыг хангасан байна;
- Системд ноцтой алдаа, өөрчлөлт гарсан болон болзошгүй тохиолдлуудыг мэдэгдэх, тухайн үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны заавартай байна;
- Бүх төрлийн вирус, спам, exploit нэвтрэх боломжийг хаасан байна;
- Системд ашиглах серверт программ хангамжуудыг суулгаж тохируулахдаа нууцлал хамгаалалтын талаас хийгдэх ажлуудыг захиалагч талын томилсон ажилтнуудтай хамт хийж, систем ажиллах сервер, сүлжээний бусад тоног төхөөрөмжүүд, тэдгээрийн зохион байгуулалт нь нууцлал хамгаалалтын хувьд шаардлага хангаж байгаа эсэхийг шалган зөвлөмж гаргуулж, сайжруулна;
- Гүйцэтгэгч системийн ашиглалтын үеийн нууцлал хамгаалалт, аюулгүй байдал, ашиглалтын зөвлөмж гаргана;
- Хэрэглэгчийн нууц үгийг кодлох бөгөөд кодлох арга нь нэг талын алгоритм байх эсвэл тоон гарын үсгийг дэмжиж ажилладаг байна;
- Нэгдсэн платформд ажиллаж байх үед сүлжээ болон техник хангамжид гарсан алдаанаас болж мэдээлэл алдагдахгүй байх боломжийг бүрдүүлсэн байна.
- Хөгжүүлэлтийн үед Secure coding practices буюу сайн туршлагыг ашиглах SQL Injection болон Buffer overflow зэрэг түгээмэл байдаг эмзэг байдлыг гаргахаас сэргийлэх
- Оролтыг хянах: Хэрэглэгчээс оруулах утгуудыг нягтлан шалгаж, Injection төрлийн халдлагаас сэргийлэх.
- Анализ хийх: Кодод анализ хийх

10.3. Системийн зохицуулагч

- Мэдээлэл илгээгч байгууллагуудыг нэмэх хасах өөрчлөх
- Мэдээлэл илгээгч байгууллагуудын эрх бүхий хэрэглэгчдийг нэмэх хасах өөрчлөх боломжтой байна;
- Мэдээлэл илгээгч байгууллагуудын хэрэглэгчдийн адилаар тухайн байгууллагын өмнөөс илгээх боломжтой байна;
- Илгээсэн мэдээллийн талаарх бүхий л статистик тоон мэдээллийг сонгосон хугацааны дагуу авах боломжтой байна.

11. Өгөгдлийн сангийн бүтэц

- Өгөгдлийн сангийн бүтэц, архитектурын шаардлагыг тодорхойлох, загварчилж батлуулан, зохион байгуулах;
- Өгөгдлийн сангийн бүтцийн диаграмм гаргах;
- Өгөгдлийн сан нь ХУР систем, төрийн байгууллагуудын сангуудтай өгөгдөл солилцох боломжтой байх;
- Цаашид өргөтгөх, шинэчлэх, засварлах боломжтой байх;

- Өгөгдлийн сангийн архитектур нь өгөгдлийн хэмжээнээс хамаарахгүй өөрчлөгдөх боломжтой байна;
- Өгөгдлийн санд холболт хийхэд хэрэглэгч нь зөвхөн өөрийн схемд ажиллах эрхтэйгээр үүсгэгдсэн байна;
- Төрийн үйлчилгээний нэгдсэн системд харьяалагдах өгөгдлийн сангууд нь өөр хоорондоо зохицон ажиллах боломжтой, өгөгдлийг харилцан солилцох, нягтлан шалгах чадвартай байна;
- Өгөгдлийн сангийн эх үүсвэр нь тодорхой байх үүднээс өгөгдлийн санд хандсан бүх хандалт болон хэрэглэгчдэд өгсөн хариултууд, оролт гаралтуудын логоуд (серверийн аюулгүйн байдлын тэмдэглэлүүд буюу security logs)-ыг хадгална;
- Өгөгдлийн сангууд, түүнийг удирдан ажиллуулах бүтцийг үүсгэхдээ мэдээллийн технологийн сүүлийн үеийн ололтыг ашиглана.
- Өгөгдөл хадгалах: Хэрэглэгчийн эмзэг мэдээллийг шифрлэж хадгалах
- Өгөгдөл дамжуулах; Хэрэглэгчийн эмзэг мэдээллийг дамжуулахдаа /server client app/ шифрлэлт ашиглах
- Өгөгдлийг багасгах: Аппликешныг цуглуулж хадгалах өгөгдлийг хамгийн бага байлгах
- Хандалт удирдлага: Эмзэг мэдээлэлд хандах хандалтыг хязгаарлаж, хандалтад хяналтыг хийх

12. Найдвартай ажиллагаа

- Үндэсний дата төвийн үүлэн тооцооллын дэд бүтцэд байршуулна;
- Системд алдаа, доголдол илэрсэн тохиолдолд алдааны мэдэгдлийг илгээх боломжтой байх;
- Өгөгдлийн санг дахин сэргээх зорилгоор системийн үндсэн байршлаас өөр газарт давхар байршуулахаар зохион байгуулна. Тухайн өгөгдлийн санг 24 цагаас ихгүй хугацаанд баяжуулж байна.
- Шинээр гарч буй халдлага, эмзэг байдлаас сэргийлж, систем апп-д шинэчлэлтийг тогтмол хийх
- Системд илэрсэн эмзэг байдлыг мэдээлэх хамгаалалт бүхий сувагтай байх

В. ТУРШИЛТ БА БАТАЛГААНЫ ШААРДЛАГА

13. Нэвтрүүлэх ажлууд

- Нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг захиалагчаар батлуулан хэрэгжүүлнэ.

14. Нийтэд таниулах, сурталчлах

- Иргэдэд сурталчлан таниулах үйл ажиллагааны төлөвлөгөөг захиалагч талаас саналыг авч боловсруулан батлуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчилна.

15. Сургалт, дадлага

- Системийн алдааг хүлээн авах, үйл ажиллагааны талаар зааварчилгаа өгөх дуудлага хүлээн авах операторыг баталгаат хугацааны туршид ажиллуулна;
- Үндэсний дата төвийн хариуцан ажиллах 2-оос доошгүй ажилтан сургах;
- Системийн зохицуулагчид танхимын хэлбэрээр 1 удаа, онлайн сургалтыг 3 удаагийн давтамжаар сургах;
- Системийг ашиглах гарын авлагыг цахим болон товхимол хэлбэрээр бэлтгэж өгөх, /видео анимэйшн, товхимол/;
- Байгууллагуудын системийн зохицуулагчид зориулсан API ашиглах, сервис солилцох заавар боловсруулан цахим хэлбэрээр байршуулна.

16. Туршилт хийх

- Үйл ажиллагааны хүрээнд дараах туршилтуудыг хийнэ. Үүнд:
 - Системийн хэрэглэгчийн түвшний тест;
 - Зохицуулагчийн түвшний тест.
- Мэдээллийн технологийн хүрээнд дараах туршилтуудыг хийнэ. Үүнд:
 - Ачаалал даах чадварын тестийг хийж үр дүнг тайлагнах;
 - Техникийн саатал гарсан, сүлжээний холболт тасарсан үед хэрэглэгчдэд энгийн ойлгомжтой алдааны мэдэгдэл харуулах;
 - Алдааны мэдэгдлийн тест;
 - Процессын дагуу ажиллаж буй эсэх дэд модулиудын хэвийн үйл ажиллагааны тест хийж үр дүнг тайлагнан захиалагчид хүлээлгэн өгнө.

17. Баталгаат хугацаа

- Баталгаат хугацааны явцад гүйцэтгэгч нь үнэ төлбөргүйгээр Техникийн тусламж захиалагчид үзүүлнэ;
- Системийн хурдан ажиллагаанд чиглэгдсэн кодчиллын сайжруулалтыг тогтмол хийх;
- Баталгаат хугацаа 12 сар байна.

18. Гүйцэтгэх хугацаа

- Системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх хугацаа 4 сар байна.


ХЯНАСАН:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Г.ЭРДЭНЭБААТАР

ДОТООД ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.НАСАНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН



Ц.НЭРГҮЙ

--- оОо---